

БАТЛАВ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА *Ч.Мөнхтуяа* Ч.МӨНХТУЯА

2024 оны 07 дугаар сарын 04 – ны өдөр

## ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ ХЭРЭГЦЭЭНД ШААРДЛАГАТАЙ ТОС, ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолтод Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны 2024 онд хэрэгцээнд шаардлагатай автомашин, механизм, тоног төхөөрөмжүүдийн тос, тослох материалд тавигдах техникийн шаардлага болон тоо хэмжээг тусгасан болно.

### 2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Олон улсын авто инженерүүдийн холбооны SAE, АНУ-ын нефть судлалын хүрээлэнгийн API стандартын шаардлагуудыг тус тус хангасан байна.

Монгол улсад тос тослох материалын албан ёсны борлуулагчтай эсэх зэргийг тодорхойлсон байх шаардлагатай.

#### 2.1 Нийлүүлэгчид тавигдах шаардлага

- 2.1.1 Нийлүүлэгч нь тухайн чиглэлээр 2-оос доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай байна,
- 2.1.2 Нийлүүлэгч нь стандарт, шаардлагыг хангасан өөрийн агуулахтай байна,
- 2.1.3 Үйлдвэрийн болон тээвэрлэлтээс үүдэлтэй үүссэн гэмтэл, шинж чанарын өөрчлөлт зэргийг бүрэн хариуцана, зөрчлийг арилгана,
- 2.1.4 Нийлүүлэгчийн зүгээс чанарын баталгаа гаргана,
- 2.1.5 Тос тослох материалын техникийн үзүүлэлтийг харуулсан баримт бичгийг монгол хэл дээр ирүүлнэ,
- 2.1.6 Барааг өөрийн тээврийн хэрэгслээр эцсийн цэгт хүргэнэ.

#### 2.2 Тос тослох материалд тавигдах шаардлага

- 2.2.1 2022 оноос хойш үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын савтай байх бөгөөд үйлдвэрийн лац, ломботой байна,
- 2.2.2 Үйлдвэрлэсэн хугацаа тэмдэглэгдсэн байх,
- 2.2.3 Өвөл болон зуны улиралд зориулсан мэдээллийг агуулсан тэмдэглэгээтэй байх,
- 2.2.4 Хөдөлгүүрийн эд ангийг бохирдолт, элэгдэл, исэлдэлтээс дээд зэргээр хамгаалсан байх,
- 2.2.5 Ашиглалтын хугацаанд зуурамтгай шинж чанараа хадгалдаг байх,
- 2.2.6 Хэт хүйтэн болон халуун хэмд тослох шинж чанараа хадгалдаг байх.

### 3. ТОС, ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТОО ХЭМЖЭЭ

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	API буюу түүнтэй дүйцэх	SAE буюу түүнтэй дүйцэх	Савалгааны багтаамж	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Тосол	Царцаж эхлэх хэм -40C		5	кг	600
2	Орос дизель хөдөлгүүрийн тос M-10DM	CD	30	4	л	200
3	Бензин хөдөлгүүрийн тос	SN, SM, SL	5W30	4	л	1400
4	Дизель хөдөлгүүрийн тос	CI-4, CH-4, CG-4	10W30	5	л	1300
5	Дизель хөдөлгүүрийн тос	CI-4, CH-4, CG-4	15W40	20	л	2600
6	Механик хурдны хайрцагны тос	GL-4, MIL-L2105	80W90	4	л	800
7	Антифриз /Улаан/	Этилен гликоль	Царцаж эхлэх хэм - 40C	5	кг	500
8	Автомат хурдны хайрцагны тос ATF Dexron III ба түүнээс дээш	-	ATF multi	20	л	200
9	Товуд EP-2	-	-	16	кг	176
10	Гидрийн шингэн ВМГЗ /Орос/	-	-	20	л	600
11	Гидрийн шингэн DTE10, excel 15	-	-	200	л	1048
12	Тоормосны шингэн DOT-4 /Сайн чанарын/	J1703	DOT-4	0.5	л	22
13	Шингэн товуд EP-023	NLGI 000		15	кг	45
14	Автомат хурдны хайрцагны тос		ATF SP-IV	4	л	64

### 4. ХҮЛЭЭН АВАХ


Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан тос, тослох материалыг нийлүүлнэ.

ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр тос, тослох материалыг хүлээн авсанд тооцно.

Ачааг хүргэх цэг: Улаанбаатар хот, Буянт-Ухаа, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албанд өөрийн тээврийн хэрэгслээр хүргэх

**Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:**

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа  
Газрын тусгай үйлчилгээ, шатахуун  
хангалтын албаны дарга,  
Үнэлгээний хорооны дарга:



Н. Баттөр

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан  
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн,  
Үнэлгээний хорооны нарийн бичиг:



Б. Алтангэрэл

Иргэний нисэхийн үндэсний төвийн  
Харьяа Газрын тусгай үйлчилгээ, шатахуун  
хангалтын албаны Шатахуун хангалтын хэсгийн  
Шатахууны сав тоноглолын инженер,  
Үнэлгээний хорооны гишүүн:



О. Болд-Эрдэнэ

“ХУД яармаг”  
Төрийн бус байгууллагын гишүүн,  
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Ж. Бямбасүрэн

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”  
Төрийн бус байгууллагын гишүүн,  
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



О. Баярсайхан